

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дулааны станцын үндсэн ба туслах тоноглолыг шинэчлэн сайжруулахгүй бол үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөг нэмэгдэх, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангаж дийлэхгүй байх суурь шалтгаан болж үйлдвэрийн газрын алдагдлыг нэмэгдүүлж байна.

АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ ЭНЕРГО" ОНӨААТҮГ-ЫН
2023, 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ДА-2025/02/ҮА-ОНА

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар

Сүхбаатар сум
2025 он

Цахим хуудас: selenge@sankhuuaudit.se.gov.mn

Дотоод аудитор: Г.Дорждэрэм

Холбоо барих утас: 7036-8811

Цахим хаяг: Dorjderem@sankhuuaudit.se.gov.mn

Энэхүү дотоод аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ᠰᠡᠯᠡᠨᠭᠡ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠰᠠᠨᠬᠡᠭᠡᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠤ,
ᠳᠣᠲᠤᠭᠠᠳᠤ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ

Товчилсон үгийн жагсаалт

ДАМПОУС	Дотоод Аудитын Мэргэжлийн Практикийн Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бэлэн мөнгөний зарцуулалтын урсгалд хийсэн сүүлийн 5 жилийн судалгааг харуулав	7
Хүснэгт 2	Цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэл	8
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг он тус бүрээр харуулав	9
Хүснэгт 4	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт	10
Хүснэгт 5	Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөлт	12
Хүснэгт 6	Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэл	13
Хүснэгт 7	Аудитын дүгнэлт, Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	14

Дүрслэлийн товъёг

д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Цалингийн сангийн гүйцэтгэлийг үндсэн болон нэмэгдэл цалингийн өсөлттэй харьцуулав	8

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН
ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт:</p>	<p>“Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ”-ын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Тус газрын 2023-2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материалыг хамруулав.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт :</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль • Татварын ерөнхий хууль • ТБОНӨХБАҮХАТ • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Хөдөлмөрийн тухай хууль, • Нийгмийн даатгалын тухай хууль • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль • Хувь хүний орлогын албан татварын тухай хууль • Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтаар баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм • Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтын шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” • Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 2 дүгээр хавсралтаар баталсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм • Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 458 дүгээр тогтоолоор батлагдсан “Тариф батлах тухай” • Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 681 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф” • Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт/тариф/-ын хэлэлцээр • “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны хамт/тариф/-ын хэлэлцээр • “Сэлэнгэ Энерго” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм • Аймгийн Засаг даргатай байгуулсан 2023-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө • “Сэлэнгэ Энерго”-ын хүний нөөцийн бодлогын баримт бичиг • Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг • Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Байгууллагын засаглалын тогтолцоо,

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2000 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор 100 хувь орон нутгийн өмчтэй "Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ болон зохион байгуулагдаж, дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус үйлдвэрийн газар нь 2024 оны байдлаар Сүхбаатар суманд КЕВ-25/14 маркийн 2, КВТС-20/150 маркийн 2, нийт 4 зуухаар дулааныг үйлдвэрлэн 65.4 /хос/ км төв ба салбар шугам, 8 дулаан хуваарилах төвөөр дулаан түгээж жилд 44.2 мян.тн нүүрс, 4.27сая.кВт/ц цахилгаан эрчим хүч, 85 мян.м³ ус хэрэглэж, 108.8 мян.Гкал дулаан үйлдвэрлэж, нийт 335 албан байгууллага, аж ахуйн нэгж, 53 төсвийн байгууллага, 3019 айл өрхөд 102.1 мян.Гкал дулааны эрчим хүч түгээж ажилласан байна.

Тус үйлдвэрийн газрын батлагдсан орон тооны дээд хязгаарыг дүрэмд 124 байхаар заасан боловч дүрэмд өөрчлөлт оруулалгүйгээр Засаг даргаар батлуулсан үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөг 2023 онд батлуулахдаа 127 болгож тус онд гүйцэтгэлээр 120 үүнээс /Эмэгтэй 40, эрэгтэй 80/, байсан бол 2024 онд орон тооны дээд хязгаарыг 128 болгон нэмэгдүүлж гүйцэтгэлээр 115 албан хаагч ажиллаж байна. Үүнээс /Эмэгтэй 41, эрэгтэй 74/ орон тооны хангалт 89.8 хувьтай ажилласан байна.

Хүйсийн харьцаагаар нь авч үзвэл эрэгтэй 56.4 хувь эмэгтэй 29.4 хувийг эзэлж байгаа бол боловсролын түвшингээр авч үзвэл дээд боловсролтой 35, тусгай дунд боловсролтой 42, бүрэн болон бүрэн бус боловсролтой 30 ажилтан байна.

Үйлдвэрийн газрын засаглалыг сайжруулахад эрх бүхий дээд байгууллага болох аймгийн ИТХ-ийн хяналтыг эрчимжүүлэх замаар үйл ажиллагааны тайланг сонсох хэлбэр төдий бус бодлогын түвшинд шийдвэр гарах түүнийг хэрэгжилтийг хангуулахад чиглэх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Гүйцэтгэх удирдлагын түвшинд үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар шинэчлэн боловсруулж гүйцэтгэх удирдлагын менежментийг сайжруулахад удирдлагаас шалтгаалах тооцоо судалгаа мэдээ мэдээлэл хүрсэн үр дүн, байгууллагын ашигт ажиллагааг дээшлүүлэхэд шаардлагатай шийдвэрийн төслийг боловсруулан ИТХ-аар хагас бүтэн жилээр хэлэлцүүлж байх нь зүйтэй юм.

1.2 Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Тус үйлдвэрийн газрын засаглалын тогтолцооны нэг хэсэг болох эрсдэлийн удирдлагын чиглэлээр удирдлага болон ажилтан албан хаагчид эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах талаар мэдлэг, чадвар дутмаг байна. Эрсдэлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах механизм бүрдээгүй эрсдэлээ бүртгэж үнэлж дүгнэх, хариу арга хэмжээг авахгүй байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүйг илэрхийлж байна.

Иймд эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- *Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбогдуулан эрсдэлийг /хүний нөөцийн, үйлдвэрлэлийн, үйл ажиллагааны, стратегийн, санхүүгийн , нийгэм, засаглалын, мэдээлэл технологийн, зах зээлийн, байгаль орчин, бусад гэх мэт/ ангилан цех газар хэлтэс бүрээр бүртгэх*
- *Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах*
- *Эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг Эрсдэлийн удирдлагын менежментийн ISO 31000 стандарт, MNS ISO 31010:2016 Эрсдэлийн үнэлгээний арга, MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн удирдамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй юм.*

1.3 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо

Тус үйлдвэрийн газар нь дотоод хяналтыг зохион байгуулах журмыг боловсруулан байгууллагын даргын 2023 оны А/36 дугаар тушаалаар батлуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг 1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд тус журмын дагуу гүйцэтгэх дотоод хяналтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах үйл явц хангалтгүй байна.

Цаашид гүйцэтгэх удирдлагын зүгээс чиг үүргийн хэрэгжилтийг хангахдаа эрсдэл, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх замаар дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн

ТБОНӨТХуулийн 77 дугаар зүйлд "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх эрхтэй "гэж заасан боловч "Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ нь 2024 оны үйл ажиллагааны тайлан, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсээс тус үйлдвэрийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 82.3 хувь, 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 86.3 хувьтай үнэлсэн байна.

2.2 Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан тарифын хэрэгжилтийн, үр нөлөө

Тус газар нь ЭХЗХ-ны 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 458 дугаар тогтоолоор 2,166 төгрөг/м³ болгон нэмэгдүүлсэн боловч уг тарифыг 2023 оныг дуусталх 4 жилийн хугацаанд мөрдөөгүй байна.

Тухайн үнэ тарифыг дэлхий дахинд тархсан "Ковид" цар тахлын улмаас улс орон даяар гамшгийн үеийн хорио цээрийн дэглэмийг мөрдүүлэх улмаар эдийн засгийн нөхцөл байдал сэргэх хүртэлх хугацаанд аймгийн удирдлагаас батлагдсан үнэ тарифыг мөрдөхийг хойшлуулсан шалтгааны улмаас тус үйлдвэрийн газар нь 2020-2023 онуудын хооронд 2 тэрбум төгрөгийн алдагдлыг хүлээж өр төлбөрийн хэмжээ нэмэгдсэн байна.

Харин цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл, инфляцын өсөлтэй уялдуулан ЭХЗХ-ноос 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 681 дүгээр тогтоолоор үйлдвэр, аж

ахуйн нэгж, айл өрхийн дулааны тарифыг шинэчлэн баталсныг 2024 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн байна.

2.3 Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт

Тус үйлдвэрийн газар нь 2024 онд өөрийн эзэмшилд бүртгэлтэй нийт 3,349 м² талбай бүхий 5 газрын хэмжилт, хянан баталгаажуулалтын ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар гүйцэтгүүлж, “Арвижих-Эсмитэйт үнэлгээ” ХХК-аар газрын үнэлгээг тогтоолгон, тухайн үнэлгээг үндсэн хөрөнгийн бүртгэлд тусган бүртгэлийн үнэн зөв байдал, ашиглалт, хамгаалалтыг сайжруулсан байна.

ОНӨГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4,406.1 мянган төгрөгийн ашиглагдахгүй байгаа тавилга, эд хогшлыг шаардлагатай байгууллагад нь балансаас балансад шилжүүлэх саналыг аймгийн ОНӨГ-аар дамжуулан Аймгийн ИТХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 160 дугаар тогтоолоор шийдвэрлүүлж цаашид ашиглах боломжгүй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн нийт 83,594.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2024 оны 158 дугаар тогтоолоор, акталж, устгах шийдвэрийг үндэслэн данс бүртгэлээс хасаж устгалд оруулсан байна.

Аудитын явцад үндсэн хөрөнгийн дансанд хэсэгчилсэн хяналтын тооллого явуулж өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг шалгахад үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн 7 нэр төрлийн 13.612.2 мянган төгрөгийн хөрөнгө, үндсэн хөрөнгийг шинж чанарыг хангахгүй /хөшиг, шатар, даам/ зэрэг бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн асуудлыг тооллогын үр дүнгээр хэлэлцэн шийдвэрлэж холбогдох залруулгын арга хэмжээг авч ажиллаагүй байна.

2.4 “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдал

Тус үйлдвэрийн газрын шинээр томилогдсон удирдлагын зүгээс аудитад хамрагдсан 2023-2024 онуудад гүйцэтгэх удирдлагын менежментийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд дараах эерэг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- *Аймгийн Засаг даргаар батлуулсан 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд алдагдлын зорилтод түвшинг 1,560,785.6 мянган төгрөг байхаар батлуулсан боловч гүйцэтгэх удирдлагын менежментийг сайжруулсны үр дүнд тайлан жилийн эцэст алдагдлын хэмжээг өмнөх оныхоос 1,010,841.6 мянган төгрөгөөр, тайлант онд 1,128,005.0 мянган төгрөгөөр буюу 72.3 хувиар бууруулж хүлээн зөвшөөрсөн алдагдлыг 432,780.2 мянган төгрөгт хүргэн үйлдвэрийн газрын эдийн засгийн зорилтод түвшнийг ханган ажилласан байна.*
- *2024 онд үйл ажиллагааны орлогыг 9,187,681.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 10,748,466.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,107,461.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 10,540,241.9 мянган төгрөгийн зардал гаргаж, баталсан орлогын төлөвлөгөөг 919,780.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, зардлыг 208,224.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.*
- *Өмнөх оноос авлагын үлдэгдэл 193,457.3 мянган төгрөгөөр, өр төлбөр 244,966.5 мянган төгрөгөөр тус тус бууруулан ажилласан.*
- *Зөрчилтэй хэрэглэгчдийг илрүүлж, зөвшөөрөлгүй хийсэн дулааны холболтуудыг таслан зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажилласан.*
- *Дулааны шугамд шинээр холбогдсон айл өрх, ААН-ыг мэдээллийн санд бүртгэж төлбөрийн тооцоонд оруулсан.*

- Зуух, насосны тохируулга, алдагдлын шалтгааныг олж бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд цахилгаан хэрэглээ 2022 онд 4440 мян. кВт байсныг 2023 онд 3010.8 мян. кВт болгон бууруулсан.
- Зуух, шугам хоолойн урсгал болон их засварын ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн ажилласны үр дүнд цахилгаан, дулаан, усны алдагдлыг бууруулсан.
- Жил бүр үйл ажиллагааны орлого нэмэгдэж байгаатай холбогдуулан санхүүгийн сахилга бат, үйлдвэрийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр сүүлийн 2 жилийн хугацаанд бэлэн мөнгөний зарцуулалтыг урсгалыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Бэлэн мөнгөний зарцуулалтын урсгалд хийсэн сүүлийн 5 жилийн судалгааг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.

/мянган төгрөгөөр/

Огноо	Нийт төвлөрүүлсэн орлого	Орлого		Харилцахаас кассад татсан бэлэн мөнгө	Бэлэн мөнгөний зарцуулалт	Харилцахаас татаж зарцуулсан бэлэн мөнгө	Нийт төвлөрүүлсэн орлогоос бэлэн мөнгөөр зарцуулсан хөрөнгийн дүнд эзлэх хувь
		Харилцах дансанд төвлөрүүлсэн орлого	Кассын орлого				
2020	5,993,330.4	5,669,000.0	324,330.4	621,645.0	945,975.4	11.0	15.8
2021	7,790,774.2	7,633,000.0	157,774.2	760,275.0	918,049.2	10.0	11.8
2022	8,162,419.9	7,942,000.0	220,419.9	133,407.0	353,826.9	1.7	4.3
2023	8,370,384.9	8,139,000.0	231,384.9	10,439.3	241,824.2	0.1	2.9
2024	10,853,293.3	10,580,000.0	273,293.3	-	254,113.2	-	2.3

Дээрх хүснэгтээс харахад 2020 онд бэлэн мөнгөний зарцуулалтын урсгал төвлөрүүлсэн орлогын 15.8 хувьд хүрч байсан нөхцөл байдлыг 2024 он гэхэд 2.3 хувьд хүргэн бууруулахын зэрэгцээ харилцах данснаас кассын зузаатгал хийж зарцуулах үйл ажиллааг бүрэн зогсоож мөнгөн хөрөнгийн зарцуулалтад удирдлага, санхүүгийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж санхүүгийн сахилга батыг дээшлүүлэн ажилласан байна.

2.5 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүргийн шинжилгээ хийсэн эсэх.

Аудитад хамрагдсан 2023-2024 онуудад тус үйлдвэрийн газраас байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх талаарх чиг үүргийн шинжилгээ судалгааны ажил хийгдээгүй байна.

Харин 2025 оны 1 дүгээр сард тус газрын даргын тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлыг хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2 дугаар улирлын байдлаар 17 албан тушаалын тодорхойлолтын чиг үүргийг тодорхой болгох ажлыг гүйцэтгэсэн явцтай байна.

2.6 Хүний нөөцийн бодлого төлөвлөлт.

Тус үйлдвэрийн газрын даргын 2018 оны 56 дугаар тушаалаар баталсан 2018-2025 онуудад мөрдөх хүний нөөцийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, эрчим хүчний салбарын бодлого, ажиллагсад тавигдах шалгуур үзүүлэлт, хүний нөөцийн талаар баримтлах залгамж чанарт үндэслэн боловсруулсан бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Гэвч хүний нөөцийн хариуцлагагүй буруутай үйл ажиллагааны улмаас аудитад хамрагдсан хугацаанд нийт ажиллаж байгаа албан хаагчдын 63.1 хувь буюу 94 албан

тушаалын тодорхойлолтгүй, 64 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллуулж ажлын гүйцэтгэлийг үнэлж баталгаажуулаагүй, хариуцлагын тогтолцоог алдагдуулсан байна.

Дээрх зөрчил дутагдалтай холбоотойгоор гүйцэтгэх удирдлагын зүгээс тухайн албан тушаалтныг ажлаас чөлөөлж дээрх зөрчил дутагдлыг арилгах арга 2025 оны 1 дүгээр сараас эрчимтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.7 Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын талаар.

Тус үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 2023 онд 127, 2024 онд 128 байхаар тооцож цалингийн сангийн зардлыг 2024 онд өмнөх оноос 35.6 хувь буюу 860,743.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Цалингийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2

/мянган төгрөгөөр/

д/д	Тайлант он	Төлөвлөгөө			Гүйцэтгэл			Зөрүү	
		Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Нэг ажилтны дундаж цалин	Орон тоо	Цалингийн сан	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
1	2023	1,587.1	127.0	2,418,734.0	1,690.2	120.0	2,401,077.9	(5,115.0)	99.8
2	2024	2,135.1	128.0	3,279,477.0	2,207.0	115.0	3,174,139.0	(127,885.0)	96.1
	Дүн	548.0	1.0	860,743.0	516.8	(5.0)	773,061.1	(122,994.1)	89.8
	Дүнд эзлэх хувь	134.5	-	135.6	130.6	-	132.2		

Дээрх хүснэгтээс харахад 2023 онд орон тооны хангалт 99.8 хувьтай 2024 онд 96,1 хувьтай цалингийн зардлыг гүйцэтгэлийн өмнөх онтой харьцуулахад 737,973.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд албан хаагчдын цалинг 35.6 хувиар нэмэгдүүлэхээр баталснаас бодит гүйцэтгэлээр 30.6 хувиар нэмэгдүүлсэн боловч нэг ажилтанд оногдох дундаж цалин хөлсийг 2024 онд төлөвлөснөөс 71.9 мянган төгрөгөөр хэтрүүлж 2,207.0 мянган төгрөг болгосон нь өмнөх оны нэг ажилтанд оногдох дундаж цалин хөлсийг 516.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Цалингийн сангийн гүйцэтгэлийг үндсэн болон нэмэгдэл цалингийн өсөлтэй харьцуулбал

Дүрслэл 1

/мянган төгрөгөөр/



Аймгийн Засаг даргаар батлуулсан тус үйлдвэрийн газрын санхүүгийн төлөвлөгөөгөөр батлагдсан цалингийн сангийн гүйцэтгэл 2024 онд үндсэн цалинг өмнөх оноос 23 хувиар, нэмэгдэл цалинг 50.9 хувиар нэмэгдүүлсэн нь нийт цалингийн зардлын гүйцэтгэл 32.2 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

Энэ нь тус үйлдвэрийн газрын зардлыг өсгөж алдагдлын хэмжээг өсгөх суурь шалтгаанд нөлөөлж байгаа боловч нөгөө төлөөрөө үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахад албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах, хүний нөөцийн дутагдал орохгүй байхад эерэг нөлөө үзүүлж байна.

Цаашид тус үйлдвэрийн газрын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулахад гаа боловч алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэрийн газрын зардлыг

2.8 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт

"Сэлэнгэ энерго" ОНӨААТҮГ-т 2023-2024 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1,566,176.3 мянган төгрөгийн 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг он тус бүрээр дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 3

Он	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт				/мянган төгрөг/	
	Аймгийн ХО		Сумын ХО		Нийт хөрөнгө оруулалтын дүн	
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
2023 он	4	632,000.0			4	632,000.0
2024 он	5	806,176.3	2	128,000.0	7	934,176.3
Дүн	9	1,438,176.3	2.0	128,000.0	11	1,566,176.3

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онуудад нийт 9 төсөл арга хэмжээнд 1,438,176.3 мянган төгрөгийг тус үйлдвэрийн газарт сүлжээний насосыг шинэчлэх, дулааны дээврийн засвар, УТ-5 худгаас ДХ-7.5 худаг хүртэлх дулааны 2ф150 мм шугамыг шинэчлэх, ТЗЦТП-1-ээс салбарласан ДХ-34.7 худгаас ДХ-13.3 худаг хүртэлх 2ф89мм хэрэглээний халуун усны шугам шинэчлэх, Баянханы 4-р багт байрлах ДХ-2.14 худгаас ДХ-2.15 худаг хүртэлх 2ф100мм диаметртэй шугамыг өргөтгөж 2ф125мм болгох ажлуудыг шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар сумын хөрөнгө оруулалтаар 2024 онд, станцын хос тэжээлийн 2800м кабель утсыг худалдан авч солих, Орхон 6-р багт байрлах ДХ-21.2 худгаас ДХ-24.18 худаг хүртэл шинээр 2ф89мм дулааны шугамын өргөтгөлийг хийж ачаалал шилжүүлэх ажлыг 128,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Эдгээр дулааны станцын туслах тоноглолыг хэсэгчлэн шинэчлэхэд оруулсан байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх өсөн нэмэгдэж байгааг хэрэглээний ачааллын тодорхой хэсгийг зохицуулахад чиглэгдэж байгаагаас дулааны станцын үндсэн ба туслах тоноглолыг шинэчлэн сайжруулж үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртгийг бууруулах, насжилт өндөртэй шугам сүлжээг шинэчилж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлэхгүй байна.

Учир нь тус дулааны станц нь 1989 онд ашиглалтад орж өдгөө 36 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд станцын насжилтын хугацаа дууссан, үйлдвэрийн өртөг тооцох гол нөлөөлдөг цахилгаан, нүүрс, усны зарцуулалт өндөртэй үр ашиг муу хуучирсан тоноглолд

сүүлийн 15 жилийн хугацаанд үндсэн тоноглол болох халаалтын зуухнууд болон туслах тоноглолд дорвитой техник шинэчлэлт хийгдээгүй улмаас байгууллагын тогтвортой үйл ажиллагааг хангахгүй болж алдагдалтай ажиллах шалтгаан нөхцөлийг бий болгосон байна.

Иймд дулааны станцын үндсэн ба туслах тоноглолыг орчин үеийн бүтээмж өндөртэй тоног төхөөрөмжөөр шинэчлэн сайжруулах замаар өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртгийг бууруулж санхүүгийн алдагдлыг бууруулахаас өөр сонголтгүй болсон байна.

Иймд дулааны станцын тоноглолын ашигт үйлийн коэффициентийг дээшлүүлэх үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөгт ойртуулах станцыг найдвартай үйл ажиллагаагаар хангах хэрэглэгчдэд чанартай дулаан түгээхэд зайлшгүй техник шинэчлэл хийж одоо мөрдөгдөж байгаа 95/70°C горимыг өөрчилж 115/70°C горимтой болгож хамааралгүй схемд шилжүүлснээр сүлжээний усыг халаах цахилгаан, нүүрсний хэрэглээний зардлыг бууруулахаас гадна аймагт шинээр баригдаж байгаа 70МВт-н дулааны цахилгаан станц ашиглалтад ороход энэхүү технологийн шинэчлэлт нь станцаас дулаанаар хангагдаж байгаа хэрэглэгчдийн халаалтын систем шууд ажиллах боломж нөхцөлийг бий болгох боломжтой болох юм.

Хэрэв технологийн шинэчлэлтийг шийдвэрлээгүй нөхцөлд одоо ашиглагдаж байгаа хуучирсан тоног төхөөрөмж нь энэхүү станцтай холбогдох боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа тул тус үйлдвэрийн газарт үндсэн болон туслах тоноглолыг шинэчлэх хөрөнгө оруулалтыг улс, орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлэхгүй бол өөрийгөө бүрэн санхүүжүүлэх боломжгүй алдагдалтай ажиллаж байгаа үйлдвэрийн хувьд бие даан шийдвэрлэж чадахгүй нь тодорхой байна.

2.9 Санхүүгийн үйл ажиллагаа

Тус үйлдвэрийн газрын нийт хөрөнгө 2024 онд өмнөх оноос 350,615.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсантай холбоотой байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 4

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,585.6	2,110.1	(4,475.5)
Авлага	1,459,594.5	1,266,137.2	(193,457.3)
Бараа материал	875,108.4	1,085,393.1	210,284.7
Үндсэн хөрөнгө	14,299,879.4	14,638,143.0	338,263.6
Нийт хөрөнгийн дүн	16,641,167.9	16,991,783.4	350,615.5
Өр төлбөр	9,349,597.9	9,104,631.4	(244,966.5)
Эздийн өмч	7,291,570.0	7,887,152.0	595,582.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,641,167.9	16,991,783.4	350,615.5

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,475.5 мянган төгрөгөөр буурсан нь 12,299,084.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 12,303,559.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

- ✓ Авлага дансны үлдэгдэл 1,266,137.2 мянган төгрөг болж 193,457.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 15,804.8 мянган төгрөгийн авлага шинээр үүсч оны эхний үлдэгдлээс 171,399.8 мянган төгрөгийн, тайлант оны авлагаас мянган төгрөгийн нийт 209,262.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.
- ✓ Бараа материал дансны үлдэгдэл 1,085,393.1 мянган төгрөг болж 210,284.7 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн УБХ-ээс 7,360.2 мянган төгрөгийн амны маск, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, Сүхбаатар сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 108,000.0 мянган төгрөгийн дулааны станцын цахилгааны шугамын хос тэжээл зэрэг нийт 115,360.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, өөрийн хөрөнгөөр мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч үйл ажиллагаандаа 3,049,917.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.
- ✓ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 17,994,011.9 мянган төгрөг болж 869,709.5 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:
 - Өөрийн хөрөнгөөр 62,463.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон /3 дугаар зуухны шинэчлэлтийн ажил 297,125.3 мянган төгрөг, дулааны станцын дээврийн засвар 94,813.6 мянган төгрөг, төв шугамын засварт 193,537.4 мянган төгрөг, 200 квт зуухны насос 260,770.0 мянган төгрөг/-ийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлсэн.
 - Аймгийн ИТХ-ын 2024 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн 160 тоот тогтоолоор ОНӨГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,406.1 сая төгрөгийн тавилга хэрэгслийг балансаас балансад шилжүүлэн бүртгэсэн,
 - Байгууллагын эзэмших эрхийн 3,349 м² талбай бүхий 5 газрыг “Арвижих - Эсмитэйт үнэлгээ” ХХК аар үнэлгээ хийлгэсэн 40,188.0 мянган төгрөгийн газрыг үндсэн хөрөнгийн бүртгэлд авсантай холбоотойгоор нийт 953,303.4 мянган төгрөгөөр нэмэгдэж аймгийн ИТХ-ын 2024 оны 158 дугаар тогтоолоор цаашид ашиглагдах боломжгүй нийт 83,594.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан хөрөнгийн бууралтаас тус тус нөлөөлсөн байна.
- ✓ Өр төлбөр дансны үлдэгдэл 9,104,631.4 мянган төгрөг болж 244,966.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 11,317,090.2 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсч оны эхний үлдэгдлээс 1,314,632.9 мянган төгрөг, шинээр үүссэн өр төлбөрийг 10,247,423.8 мянган төгрөгөөр нийт 11,562,056.7 мянган төгрөгөөр барагдуулсан байна.

Үйлдвэрийн газрын өр төлбөрийн бүтцийг эзлэх хувиар харьцуулан шинжлэхэд Нийт өр төлбөрийн 28.5 хувь буюу 2,588,676.6 мянган төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагын, 40.1 хувийг буюу 3,652,542.8 мянган төгрөгийг татварын, 28.5 хувь буюу 2,597,796.2 мянган төгрөгийг НДШ-ийн, 0.4 хувь буюу 39,699.7 мянган төгрөгийг урт хугацаат буюу хөрөнгө оруулалтын зээлийн, 2.2 хувь буюу 198,674.4 мянган төгрөгийг цалингийн илүү төвлөрүүлсэн дулааны өглөг 0.3 хувь буюу 27,241.7 мянган төгрөгийг тус тус эзэлж байна.

2.10 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөлт

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 болон 20 дугаар зүйлийн 20.3-д заасны дагуу “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулж,

гүйцэтгэлийг тайлагнаж ажилласан байна.

Хүснэгт 5

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Төлөвлөгөө		Зөрүү	Хувь
			2023	2024		
1	Борлуулалтын орлого	м/төг	6,198,404.00	7,285,307.00	1,086,903.00	118%
2	Бусад орлого	м/төг	40,357.00	102,374.00	62,017.00	254%
3	Орон нутгийн татаас	м/төг	1,800,000.00	1,800,000.00	-	100%
2	Нийт орлого	м/төг	8,038,761.00	9,187,681.00	1,148,920.00	114%
3	Нийт зардал	м/төг	9,573,390.00	10,748,466.60	1,175,076.60	112%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	147,534.00	142,693.00	(4,841.00)	97%
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(1,534,629.00)	(1,560,785.60)	(26,156.60)	102%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(1,543,629.00)	(1,560,785.60)	(17,156.60)	101%
6	Төсвийн төлбөр	м/төг	1,197,744.00	2,667,166.00	1,469,422.00	223%
	а/Орлогын татвар	м/төг		-	-	
	б/НӨАТ	м/төг	619,840.00	1,560,000.00	940,160.00	252%
	в/НДШ	м/төг	350,717.00	784,000.00	433,283.00	224%
	г/ХАОАТ	м/төг	207,018.00	265,000.00	57,982.00	128%
	д/ҮХЭХАТ	м/төг	13,704.00	25,701.00	11,997.00	188%
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	665.00	665.00	-	100%
	ё/Бусад татвар	м/төг	5,800.00	10,245.00	4,445.00	177%
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	127.00	128.00	1.00	101%
8	Нийт цалингийн сан	м/төг	2,418,734.00	3,279,477.00	860,743.00	136%
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	1,587.10	2,135.08	547.98	135%
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	1.50	0.85	(0.65)	57%
11	Хөрөнгө оруулалт	м/төг	649,255.00	512,600.00	(136,655.00)	79%
12	Нийт авлага	м/төг	1,140,802.10	1,459,537.88	318,735.78	128%
	Үүнээс: найдваргүй	м/төг		-	-	
13	Нийт өглөг	м/төг	7,831,664.00	9,349,597.97	1,517,933.97	119%
	Богино хугацаат өглөг	м/төг	7,669,127.00	9,187,860.15	1,518,733.15	120%
	Урт хугацаат өглөг	м/төг	162,537.00	161,737.82	(799.18)	100%

Дээрх хүснэгтээс харахад аудитад хамрагдсан сүүлийн 2 жилийн техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөлтөд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Борлуулалтын орлогыг өмнөх оноос 18 хувиар, бусад орлогын 2.5 дахин, нийт орлогыг 14 хувиар нэмэгдүүлэхээр, Нийт зардлыг зах зээлийн үнийн өсөлт инфляц, төсөвт төвлөрүүлэх татвартай уялдуулан 12 хувиар нэмэгдүүлэхээр тус тус төлөвлөсөн бөгөөд зардлын өсөлтийг ангиллаар нь авч үзэхэд төсөвт төвлөрүүлэх татварын зардлыг 123 хувиар, ажиллагсдын цалингийн зардлыг 36 хувиар нэмэгдүүлж, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг өмнөх оноос 0.65 буюу 43 хувиар бууруулахаар төлөвлөж 2024 оны нийт орлогыг 9,187,681.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 10,748,466.6 мянган төгрөгөөр тогтоож 1,560,785.6 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн байна. Аймаг, сумын хөрөнгө оруулалт болон өөрийн эх үүсвэрээр хийх хөрөнгө оруулалтын 4 арга хэмжээг нийт 512,600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин авлагыг 318,735,8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь 2023 онд айл өрх, албан байгууллагын дулааны хэрэглээнд тавих хяналтыг хэрэгжүүлж талбайн

хэмжилтийн зөрүүгээр үүссэн дулааны төлбөрийг барагдуулахаар нэмэгдүүлэн байна.

Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшний гүйцэтгэл

Хүснэгт 6

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл		Зөрүү	Хувь
			2023	2024		
1	Борлуулалтын орлого	м/төг	5,449,129.00	7,359,368.76	1,910,239.76	135%
2	Бусад орлого	м/төг	58,175.00	111,729.31	53,554.31	192%
3	Орон нутгийн татаас	м/төг	2,182,043.00	2,636,363.64	454,320.64	121%
2	Нийт орлого	м/төг	7,689,347.00	10,107,461.70	2,418,114.70	131%
3	Нийт зардал	м/төг	9,129,390.00	10,540,241.89	1,410,851.89	115%
	Үүнээс: Удирдлагын зардал	м/төг	116,907.00	158,434.38	41,527.38	136%
4	Татварын өмнөх ашиг	м/төг	(1,440,043.00)	(432,780.18)	1,007,262.82	30%
5	Цэвэр ашиг /алдагдал /	м/төг	(1,440,043.00)	(432,780.18)	1,007,262.82	30%
6	Төсвийн төлбөр	м/төг	1,813,305.00	2,662,136.00	848,831.00	147%
	а/Орлогын татвар	м/төг			-	
	б/НӨАТ	м/төг	1,419,875.00	1,572,428.81	152,553.81	111%
	в/НДШ	м/төг	348,546.00	783,051.40	434,505.40	225%
	г/ХАОАТ	м/төг	29,752.00	263,794.82	234,042.82	887%
	д/ҮХЭХАТ	м/төг	9,255.00	10,040.08	785.08	108%
	е/Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	м/төг	480.00	313.40	(166.60)	65%
	ё/Бусад татвар	м/төг	5,397.00	10,245.37	4,848.37	190%
7	Нийт ажиллагсдын тоо	Хүн	120.00	107.00	-	89%
8	Нийт цалингийн сан	м/төг	2,413,619.00	3,151,592.00	737,973.00	131%
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	м/төг	1,690.20	2,207.00	516.80	131%
10	Борлуулалтын орлогын 1 төг ногдох зардал	м/төг	1.70	0.96	(0.74)	56%
11	Хөрөнгө оруулалт	м/төг	509,979.60	463,700.00	(46,279.60)	91%
12	Нийт авлага	м/төг	1,459,537.00	1,266,137.18	(193,399.82)	87%
	Үүнээс: найдваргүй	м/төг			-	-
13	Нийт өглөг	м/төг	9,349,597.00	9,104,631.45	(244,965.55)	97%
	Богино хугацаат өглөг	м/төг	9,187,860.00	9,064,931.79	(122,928.21)	99%
	Урт хугацаат өглөг	м/төг	161,737.00	39,699.66	(122,037.34)	25%

“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ 2024 онд дулаан, хэрэглээний халуун усны орлого 7,359,368.7 мянган төгрөг, улсын төсвийн татаас санхүүжилтийн орлого 2,636,363.6 мянган төгрөг, нүүрс борлуулсны орлого 13,581.8 мянган төгрөг, техникийн нөхцөл болон бусад үйлчилгээний орлого 41,800.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлого, бусад үйлчилгээний орлого 56,097.7 мянган төгрөг, харилцах дансны хүүгийн орлого 249.9 мянган төгрөгийн зэрэг нийт 10,107,461.7 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлснийг өмнөх онтой харьцуулахад орлогын бүрдүүлэлтийг 31 хувиар буюу 2,418,114.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Үйлдвэрийн газрын орлого нэмэгдэх болсон шалтгаанд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- ✓ Тайлант онд 2023 онд ЭХЗХ-ноос шинэчлэн тогтоосон дулааны үнэ тарифыг мөрдөж эхэлсэн.

- ✓ Хяналт шалгалтаар зөвшөөрөлгүй дулаан хэрэглэж байсан айл өрх, албан байгууллага болон тэдний талбайн хэмжилтийг дахин хийж зөрүүг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн
- ✓ Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардлыг өмнөх оноос 0.74 функтаар бууруулж ашигт үйлийн коэффициентийг нэмэгдүүлэн ажилласан.
- ✓ Өмнөх болон тайлант онд үүссэн авлагыг барагдуулахад онцгой анхаарч ажилласан зэрэг хүчин зүйлийн үр дүнд орлого нэмэгдсэн байна.

Үүний үр дүнд тайлант онд хүлээн зөвшөөрөх алдагдлын хэмжээг 1,560,786.0 мянган төгрөгийн тооцсоныг 432,780.2 мянган төгрөг болтол бууруулж чадсан байна.

Жил бүр алдагдалтай ажиллаж өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллаж чадахгүй байгаа нь дулааны станцын насжилт өндөртэй, хуучирсан технологийн хоцрогдолд орсон засвар үйлчилгээ их шаарддаг, дулаан үйлдвэрлэлийн өртөг тооцоход гол нөлөө үзүүлж буй /цахилгаан, нүүрс, усны/ гэх мэт өндөр зарцуулалт шаардагддаг үндсэн болон туслах тоноглолоос үүдэлтэйгээр 1 Гкал дулааныг 100.5 мянган төгрөгөөр үйлдвэрлэж, 70.3 мянган төгрөгөөр худалдан борлуулж 1 Гкал дулаан тутамд 30.2 мянган төгрөгийн алдагдал хүлээх үндсэн шалтгаан болгож байна.

Нийт зардлын гүйцэтгэл 10,540,241.9 мянган төгрөг болж төлөвлөснөөс 208,226.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь удирдлагын зардал 15,741.4 мянган төгрөгөөр, шатахууны зардал 22,749.2 мянган төгрөгөөр, тогтмол зардал 166,045.9 мянган төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардал 315,164.2 мянган төгрөгөөр нийт 519,700.7 мянган төгрөгөөр хэтэрч, бусад зардал 727,926.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн зөрчил, өгсөн дүгнэлтийг дараах хүснэгтэд харуулав.

Аудитын дүгнэлт, Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 7

/мянган төгрөгөөр/

Огноо	2023 он		2024 он		Өөрчлөлт	
	Хязгаарлалтай		Хязгаарлалтай			
Үзүүлэлт	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн акт	1	236.0			(1)	(236.0)
Албан шаардлага	3	1,146,744.5	4	131,041.2	1	(1,015,703.3)
Зөвлөмж	4	120,631.8	1	-	(3)	(120,631.8)
Нийт дүн	8	1,267,612.3	5	131,041.2	(3)	(1,136,571.1)

Төрийн аудитын байгууллагаас тус үйлдвэрийн газрын 2023-2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаснаас гадна 2024 онд илэрсэн зөрчил дутагдлыг өмнөх онтой харьцуулахад илэрсэн зөрчлийн шинж чанар болон мөнгөн дүнгээр 1,136,571.1 мянган төгрөгөөр буурч санхүүгийн сахилга бат сайжирсан ололттой тал байна.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Тус үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн боловсруулж бүтэц зохион байгуулалт чиг үүргийг оновчтой тодорхой болгох замаар засаглалыг сайжруулах арга хэмжээг авахгүйгээр цаашид үргэлжлүүлэн, ашигтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй нөхцөл байдалд хүрсэн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар шинэчлэн боловсруулж засаглалыг тогтолцоог сайжруулах шаардлагатай байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно, 77 дугаар үйлийн 77.1.4-д " Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих."	
Асуудлын үндсэн шалтгаан: Байгууллагын дотоод зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалт, бүтэц, засаглалын тогтолцоог шинжилж, үнэлгээ хийж шинэчлэх үйл ажиллагааг орхигдуулсан. Үйлдвэрийн газрын дүрэмд шаардлагатай өөрчлөлт оруулаагүй, оролцогч талуудын эрх ашиг, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод байдлыг хангах зохицуулалт тусгагдаагүй байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Үйлдвэрийн газрын үр ашиг, санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, өөрийгөө санхүүжүүлэх чадамж буурах эрсдэлтэй. Ажлын байрны чиг үүрэг тодорхойгүйгээс хариуцлага, үр нөлөөний тогтолцоо сулрах, хүний нөөцийн оновчгүй хуваарилалт үүсэх. Засаглалын ил тод, нээлттэй байдал алдагдаж, оролцогч талуудын итгэл буурах.	
Шийдвэр: Цаашид үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар дүрмийн шинэчлэлийн төслийг боловсруулж аймгийн Засаг даргад танилцуулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээг авах зөвлөмж хүргүүлэх.	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүй эрсдэлийг бүртгэж үнэлэх дүгнэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх процесс хийгдэхгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөхдөө учирч болох эрсдэлүүдийг авч бүртгэж түүнийг бууруулах талаар ярилцдаг боловч баримтжуулаагүй, үнэлгээ хийгдээгүй байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: MNS ISO 31010:2016 Эрсдэлийн үнэлгээний арга MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн удирдамж Эрсдэлийн удирдлагын журам, холбогдох заавар	

Асуудлын үндсэн шалтгаан: Эрсдэлийн удирдлагын тогтолцооны талаарх ойлголт, мэдлэг дутагдалтай Бодлого, журам, аргачлал батлагдаагүй Эрсдэлийн удирдлагыг байгууллагын төлөвлөлт, гүйцэтгэлийн процессод тусгаагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах боломж алдагдана Үйл ажиллагаанд гэнэтийн доголдол, хохирол үүсэх эрсдэл өндөр Төлөвлөлт, шийдвэр гаргалтад мэдээлэл дутмаг, үндэслэл сул байх нөхцөл бүрдэнэ Тогтвортой, хариуцлагатай засаглал, менежментийн чадавх сулрах.	
Шийдвэр: Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 3	Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг сайжруулах төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжилтийн үр дүнг хангалтгүй дотоод хяналт сул байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд

Бодит байдал:
Байгууллагын хэмжээнд дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа нь албан ёсны бодлого, журамд тулгуурлаагүй, тогтсон бүтэц, төлөвлөгөөтэй бус, тохиолдлын болон хэсэгчилсэн байдлаар хэрэгжиж байна. Хэдийгээр гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор төлөвлөгөө боловсруулсан боловч түүнийг хэрэгжүүлэх явц, хяналт-шинжилгээ, үнэлгээ хангалтгүй байгаа нь бодит байдал дээр хангалтгүй байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:
Үйлдвэрийн газрын дарга Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д ".... өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцах", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3-д Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.

Асуудлын үндсэн шалтгаан:
Хяналт шалгалтын бодлого, журам боловсруулж баталгаажуулаагүй
Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх тогтолцоо бүрдээгүй

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:
Хууль, дүрэм, дотоод журмыг зөрчих эрсдэл нэмэгдэнэ
Хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн үнэн зөв байдал тодорхойгүй, ил тод бус байна
Санхүү, хөрөнгө, хүний нөөцийн үр ашиггүй хэрэглээ, хариуцлагагүй байдал бий болох эрсдэл өндөр

Шийдвэр:
Цаашид дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, үр дүнг тайлагнах **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Илэрсэн асуудал 4	Тус үйлдвэрийн газарт ажиллаж байгаа 94 ажилтан буюу 63.1% нь албан тушаалын чиг үүрэг тодорхойгүй батлагдсан ажлын байрны тодорхойлолтгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд

Бодит байдал: Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт албан ёсоор батлагдаагүй, чиг үүрэг, хариуцлага нь тодорхойгүй байгаа нь үүрэг даалгавар олгох, гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох, ажлын уялдаа холбоо бий болгоход хүндрэл үүсгэж байна. Нийт 128 ажилтны 94 нь ажлын байрны тодорхойлолтгүй ажиллаж байгаа нь байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал, үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

<p>Байх ёстой шаардлага /шалгуур Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2-т "хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг дагаж мөрдөх, ажилтанд ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний хувийг баталгаажуулж өгөх" гэсэн заалттай нийцээгүй байна.</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Батлагдсан "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй. Байгууллагын дотоод хяналт муу.</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажлын үүрэг, хариуцлага тодорхойгүй байснаар ажилтны гүйцэтгэл, хариуцлага сулрах Шийдвэр гаргалт, ажлын уялдаа холбоо доголдох Хөдөлмөрийн гэрээ, цалин хөлс, урамшуулалтай холбоотой зөрчил үүсэх эрсдэл нэмэгдэх Хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт, ажлын үр дүнг үнэлэх боломж хязгаарлагдах Ажлын бүтээмж буурах, хяналт хариуцлагагүй байдал тогтох нөхцөл бүрдэнэ</p>
<p>Шийдвэр: Цаашид ажилд орсон иргэнтэй албан тушаалын тодорхойлолтыг томилогдсон өдрөөс байгуулан баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлж байна</p>

<p>Илэрсэн асуудал 5</p>	<p>Аудитад хамрагдсан 2023-2024 онуудад тус үйлдвэрийн газарт ажилд орсон 64 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллуулсан байна.</p>
<p>Асуудлын ангилал</p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: Аудитаар шалгасан хугацаанд буюу 2023–2024 онд нийт 64 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулалгүйгээр ажиллуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 47–50 дугаар зүйлүүд, мөн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 3.2 дахь заалтыг зөрчсөн зөрчил байна. Ажилтны хөдөлмөрийн харилцааг хууль ёсны баримт бичгээр баталгаажуулаагүй нь хөдөлмөр эрхлэлттэй холбоотой эрх зүйн болон санхүүгийн эрсдэл үүсгэж байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөдөлмөрийн тухай хуулийн 47,48,49,50 дугаар зүйл, "Сэлэнгэ Энерго" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 3.2-т "Хөдөлмөрийн гэрээ байгуулах" 3.2.1-т Ажил олгогч нь ажилтантай Хөдөлмөрийн тухай хуулийн 47, 48, 49, 50 дугаар зүйлүүдийг баримтлан хөдөлмөрийн гэрээ байгуулна. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Хүний нөөцийн бүрдүүлэлт, хөдөлмөрийн гэрээ байгуулах байгуулаагүй байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Нөөцийн үр ашиггүй ашиглалт, хүний нөөцийн илүүдэл эсвэл дутагдал үүсэх эрсдэл нэмэгдэнэ</p>	
<p>Шийдвэр: Цаашид ажилд орсон иргэнтэй хөдөлмөрийн гэрээг томилогдсон өдрөөс байгуулан баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

<p>Илэрсэн асуудал 6</p>	<p>Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх талаар судалгаа 2023-2024 онуудад хийгдээгүй байна.</p>
<p>Асуудлын ангилал</p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: Байгууллага нь үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор хийх дүн шинжилгээг 2023–2024 онуудад огт хийгдээгүй байна. Үүнээс шалтгаалж ажлын байр хооронд үүрэг давхцах, эсвэл гүйцэтгэгчгүй байх зэрэг эрсдэлтэй нөхцөл бүрдсэн байна</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: "Сэлэнгэ Энерго" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн 2.6-д ... "Ажил, чиг үүргийн давхардал, ажлын ачааллын талаар судалгаа хийж, судалгааны үр дүнг үндэслэн тэнцвэржүүлэх арга хэмжээ авна" гэсэн заалтын хэрэгжилт хангагдаагүй байна</p>	

<p>Асуудлын үндсэн шалтгаан: Хүний нөөцийн төлөвлөлт, дотоод менежментийн тогтолцоо сул Судалгааны арга зүй, хэрэгжилтийг зохион байгуулах хариуцсан бүтэц, хяналтгүй Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж ажиллаагүй</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Чиг үүргийн давхардал, хийдэл нь ажлын гүйцэтгэлийг бууруулж, хариуцлага тодорхойгүй байдал бий болгоно Нөөцийн үр ашиггүй ашиглалт, хүний нөөцийн илүүдэл эсвэл дутагдал үүсэх эрсдэл нэмэгдэнэ</p>
<p>Шийдвэр: Цаашид хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

<p>Илэрсэн асуудал 7</p>	<p>Сайн дурын үндсэн дээр албан хаагчид нэг нэгэндээ мөнгөн хандив тусламж үзүүлэх үйл ажиллагааг цалингаас нэгдсэн байдлаар 2023 онд 9,080.0 мянган төгрөг, 2024 онд 9,365.0 мянган төгрөг, нийт 18,445.0 мянган төгрөгийг суутган гүйцэтгэсэн нь байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дагварыг үүсгэж байна.</p>
<p>Асуудлын ангилал</p>	<p>Нөлөө дунд</p>
<p>Бодит байдал: Сайн дурын үндсэн дээр албан хаагчид нэг нэгэндээ мөнгөн хандив тусламж үзүүлэх үйл ажиллагааг цалингаас нэгдсэн байдлаар 2023 онд 9,080.0 мянган төгрөг, 2024 онд 9,365.0 мянган төгрөг, нийт 18,445.0 мянган төгрөгийг суутгасан нь байгууллагын үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлж албан хаагчдын нийгмийн баталгаанд эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлсэн байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.2-д "Ажилтны нэг сарын цалин хөлснөөс хийх нийт суутгал нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хассан цалин хөлсний дүнгийн 20 хувиас, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, эсхүл хэд хэдэн суутгал зэрэг хийх бол цалин хөлсний 50 хувиас хэтрэхгүй байна."</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Хөдөлмөрийн хуулийн холбогдох заалтыг бүрэн баримтлан хэрэгжүүлээгүй, ажилтны санхүүгийн эрх ашгийг хамгаалах хяналт, хариуцлага сул байна.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Ажилтны цалин хөлс хууль зөрчин хэт их хэмжээгээр суутгагдах эрсдэлтэй Хөдөлмөрийн эрх зүйн маргаан, гомдол, хариуцлага үүсэх нөхцөл бүрдэнэ</p>	
<p>Шийдвэр: Цаашид Албан хаагчид хамт олноос үзүүлэх хандив тусламж цалингаас суутган тооцохгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

<p>Илэрсэн асуудал 8</p>	<p>Сарын ажлын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн үнэлгээг хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүй байна.</p>
<p>Асуудлын ангилал</p>	<p>Нөлөө их</p>
<p>Бодит байдал: Цалин хөлс, үр дүнгийн нэмэгдэл олгосон тооцооллыг тулган баталгаажуулахад: 2023–2024 оны хугацаанд байгууллага нь сар бүрийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг үйлдвэрлэлийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үр дүнг тооцсон үнэлгээгүйгээр олгосон байна. Үүний улмаас гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулал олголтын хооронд уялдаа үүсээгүй бөгөөд хөдөлмөрийн бүтээмж, хариуцлагын зарчим алдагдсан байдал ажиглагдаж байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 3.8-д "Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл үр дүнд үндэслэн /үйлдвэрийн цех хэлтэс, албадын/ албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно"</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох шалгуур үзүүлэлтийг сар бүр алба, цех, нэгжүүдийн гүйцэтгэлтэй</p>	

уялдуулан үнэлэх тогтолцоо бүрэн хэрэгжээгүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Гүйцэтгэлд суурилсан урамшууллын зарчим алдагдаж, ажлын үр дүн буурах эрсдэлтэй Санхүүгийн нөөцийг зорилтот бус, зохистой бус зарцуулж, зардал нэмэгдэх шалтгаан болно	
Шийдвэр: Цаашид албан хаагчдын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохдоо журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, үнэлгээг тухайн албан хаагчид танилцуулан хурлын тэмдэглэлээр баталгаажуулж байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 9	Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн 7 нэр төрлийн 13.612.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал: Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлийг тулган баталгаажуулах явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөө (12,900.0 мянган төгрөг), зургийн аппарат (249.0 мянган төгрөг), картын сүлжээ хуваарилагч (144.7 мянган төгрөг), сүлжээний лан карт-3 ширхэг (нэг бүр нь 15.0-255.0 мянган төгрөг), флаш 4GB (23.0 мянган төгрөг) нийт 13,612.2 мянган төгрөгийн хөрөнгийг "Тавилга эд хогшил"-ын дансанд бүртгэсэн байна. Энэ нь санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдал алдагдах эрсдэлийг үүсгэж байна	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно"	
Асуудлын үндсэн шалтгаан: Үндсэн хөрөнгийн ангиллыг тодорхойлох, хянах, баталгаажуулах дотоод хяналт сул байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Санхүүгийн тайлан, хөрөнгийн бүтэц, тайлагналд алдаа үүсэж, хөрөнгийн бодит үнэ цэнийг буруу илэрхийлж болзошгүй.	
Шийдвэр: Цаашид үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн 7 нэр төрлийн 13.612.2 мянган төгрөгийн хөрөнгийг залруулах зөвшөөрлийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэх.	

Илэрсэн асуудал 10	Тавилга эд хогшлын дансанд "хөшиг", "шатар", "даам" зэрэг бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Үндсэн хөрөнгийн "Тавилга, эд хогшил" дансанд үндсэн хөрөнгийн шалгуур хангаагүй, түр хугацаанд ашиглагдах, бараа материалын шинжтэй "хөшиг, шатар, даам" зэрэг 42 нэр төрлийн 4,321.3 мянган төгрөгийн материаллаг эд зүйлсийг бүртгэгдсэн байна. Бараа материалын ангилалд хамаарах эд зүйлсийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн нь хөрөнгийн ангилал, бүртгэл, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал алдагдах нөхцөл бүрдүүлж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: НББОУС-16, Сэлэнгэ Энержо ОНӨААТҮГ-ын НБББББ-ын 4.4.2 "Үндсэн хөрөнгө" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна	
Асуудлын үндсэн шалтгаан: Бараа, материалын анхан шатны бүртгэл, ангиллын шалгуур тодорхойгүй НББОУС болон байгууллагын НБББББ-г бүрэн хэрэгжүүлээгүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Үндсэн хөрөнгийн ангилал алдагдаж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлнө Хөрөнгийн элэгдэл тооцоолол бодит бус болж, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдана	
Шийдвэр: Цаашид үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй бараа материалыг ОНӨГ-т хүргүүлэн холбогдох	

дансанд бүртгэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 11</u>	Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2022 онд худалдан авсан 139,700.0 мянган төгрөгийн уурын зуухны /500квт/-ын хүчин чадалтай насосыг одоог хүртэл ашиглаагүй боловч 31,458.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулж хөрөнгийн үнэ цэнийг бууруулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: 022 онд аймгийн ОНХС-ын хөрөнгөөр худалдан авсан байгууллагын "Үндсэн хөрөнгө" дансанд бүртгэлтэй уурын зуухны насосыг өнөөг хүртэл ашиглалтад оруулаагүй, агуулахад байгаа хэдий ч 31.4 сая төгрөгийн элэгдлийн зардлыг бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох нөхцөлийг зөрчиж, тайлангийн бодит байдалд сөргөөр нөлөөлсөн зөрчил юм.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: НББОУС-16, Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-ын НБББББ-ын 4.4.2 "Үндсэн хөрөнгийн элэгдэл" хэсэгт "Үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааных нь туршид сонгон авсан элэгдэл байгуулах аргыг хэрэглэх ёстой. Хөрөнгийг ашиглалтад оруулсан үеэс эхлэн элэгдэл тооцно", "Ашиглалтанд тавьж олгоогүй, агуулахад байгаа болон ашиглаж эхлээгүй хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Ашиглалтад оруулаагүй хөрөнгийг шууд үндсэн хөрөнгөд бүртгэж, элэгдэл тооцсон Элэгдэл тооцох бодлого, шалгуур үзүүлэлтийг санхүүгийн алба бүрэн хэрэгжүүлээгүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Хөрөнгийн ашиглалт, элэгдэл, хорогдлын бүртгэл зөрүүтэй болж, хяналт, тайлагналд хүндрэл учруулна	
Шийдвэр: Цаашид 139,700.0 мянган төгрөгийн уурын зуух /500квт/-ын хүчин чадалтай насосыг одоог хүртэл ашиглаагүй боловч 31,458.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулж хөрөнгийн үнэ цэнийг бууруулсан алдааг залруулах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

<u>Илэрсэн асуудал 12</u>	Санхүүгийн, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бүрэн хөтлөөгүй, ажил гүйлгээгээр бүртгэл тайланд тусгасан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө дунд
Бодит байдал: Анхан шатны баримтыг тулган баталгаажуулахад: жолоочийн тооцооны хуудсанд автомашины шатахууны үндсэн норм болон зарцуулалтын тооцоог хийж баталгаажуулаагүй буюу анхан шатны баримт хөтлөх заавар аргачлалын дагуу бүрэн хөтлөөгүй, бүрдэл дутуу ажил гүйлгээгээр 2023 онд 253,149.9 мянган төгрөг, 2024 онд 243,296.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.4-т "Жолоочийн тооцооны хуудас" хэсгийг баримтлаагүй.	
Асуудлын үндсэн шалтгаан: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 347 тоот тушаалын хэрэгжилт хангагдаагүй Дотоод хяналтын тогтолцоо, санхүүгийн сахилга бат сул	

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Шатахуун зарцуулалтад хяналт тавих боломжгүй болж, үр ашиггүй зардал гарах эрсдэлтэй Санхүүгийн тайлан мэдээ буруу тайлагнагдах эрсдэлийг үүсгэж байна.	
Шийдвэр: Цаашид Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрэн хөтлөөгүй, ажил гүйлгээгээр бүртгэл тайланд тусгахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 13	Борлуулсан барааны өртөгт 24.215.5 мянган төгрөгийн Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг бүртгэсэн байна.
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал:
Байгууллагын санхүүгийн тайлангийн "Борлуулсан барааны өртөг" дүнг бүрдүүлэхдээ зарим зардлыг ангилал буруугаар бүртгэсэн байна. Тодруулбал, зөвхөн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахтай шууд холбоогүй 24.215.5 мянган төгрөгийн Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг борлуулалтын өртөгт бүртгэснээр зардлын ангилал алдагдаж, тайлангийн үнэн зөв байдал алдагдсан байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 13.1.2-т "албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гарсан байх"; Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1 дүгээр хавсралтын Гуравдугаар бүлэг-т "Орлогын дэлгэрэнгүй тайлан нь ... орлоготой холбогдож гарсан борлуулалтын өртөг болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно"

Асуудлын үндсэн шалтгаан:
Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг борлуулсан барааны өртөгт буруу тооцсон нь санхүүгийн тайлагналын журам зөрчсөн, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөөгүйтэй холбоотой.

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/ Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдаж, ашиг, өртгийн харьцаа буруу илэрхийлэгдэнэ.	
Шийдвэр: Цаашид борлуулсан барааны өртгийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв тооцож, татварын хяналт шалгалтаар үүсэх эрсдэлээс сэргийлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.	

Илэрсэн асуудал 14	Албан хаагчдад 2024 онд 6,792.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо цалин хөлс түүнтэй адилтгах шагнал урамшууллаас хувь хүний орлогын албан татварын 10 хувь болох 679,3 мянган төгрөгийг суутгаагүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал: Байгууллагаас 2024 онд албан хаагчдад 6,792.7 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг олгохдоо Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3.1-д заасан "цалин, шагнал, урамшуулал зэрэг хөдөлмөрийн орлого"-д хамаарах орлогоос суутгал хийгээгүй байна. Иймд хуульд заасан албан татварын суутгал хийгдээгүй нь татварын зөрчил үүсгэж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого"	
Асуудлын үндсэн шалтгаан: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллаагүй, бүртгэлээр тавих хяналт сул байна	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	

Байгууллагын санхүүгийн сахилга бат, татварын хариуцлагын үнэлгээнд сөргөөр нөлөөлнө
Улсын төсөвт төлөх татвар төлөгдөөгүйгээс татварын өр үүсэх, алданги, торгууль ногдох эрсдэлтэй

Шийдвэр:

Цаашид Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг баримталж ажиллах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **24,894.7** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Албан шаардлага:

- ✓ Борлуулсан барааны өртөгт **24.215.5** мянган төгрөгийн Ерөнхий ба удирдлагын үйл ажиллагааны зардлыг бүртгэсэн байна.
- ✓ Албан хаагчдад 2024 онд 6,792.7 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо цалин хөлс түүнтэй адилтгах шагнал урамшууллаас **679.3** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✓ Жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг зохицуулах, үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, ачаалал, халаалтын чанар, дулааны станцын хуучирсан насжилт өндөртэй үндсэн болон туслах тоноглолыг шинэчлэх ажлыг жил бүр үе шаттай хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлагын зүгээс бодлогын түвшинд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад тусган шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
- ✓ Аймгийн ИТХ-ын зүгээс тус үйлдвэрийн газрын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулахад бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны дээд хязгаар, хариуцлагын тогтолцоог тус үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулах замаар шинэчлэн тогтоож гүйцэтгэх удирдлагын засаглалын менежментийг сайжруулахад хяналтын тогтолцоог бий болгох хэрэгцээ шаардлага үүссэн байна.
- ✓ Тус үйлдвэрийн газрын даргын 2018 оны 56 дугаар тушаалаар баталсан 2018-2025 онуудад мөрдөх хүний нөөцийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын хууль тогтоомж, эрчим хүчний салбарын бодлого,ажиллагсдад тавигдах шалгуур үзүүлэлт, хүний нөөцийн талаар баримтлах залгамж чанарт үндэслэн боловсруулсан бодлогын баримт бичгийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан түүнд дүн шинжилгээ хийж шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн байна.
- ✓ Байгууллагын хэмжээнд эрсдэлийг удирдлагын тогтолцоо төлөвшөөгүй эрсдэлийг бүртгэж үнэлэх дүгнэх, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх процесс хийгдэхгүй байна.
- ✓ Гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг сайжруулах төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжилтийн үр дүнг хангалтгүй дотоод хяналт сүл байна.

- ✓ Тус үйлдвэрийн газарт ажиллаж байгаа 94 ажилтан буюу 63.1% нь албан тушаалын чиг үүрэг тодорхойгүй батлагдсан ажлын байрны тодорхойлолтгүй, 2023-2024 онуудад тус үйлдвэрийн газарт ажилд орсон 64 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллуулсан байна.
- ✓ Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх талаар судалгааг 2023-2024 онуудад хийгдээгүй байна.
- ✓ Сайн дурын үндсэн дээр албан хаагчид нэг нэгэндээ мөнгөн хандив тусламж үзүүлэх үйл ажиллагааг цалингаас нэгдсэн байдлаар 2023 онд 9,080.0 мянган төгрөг, 2024 онд 9,365.0 мянган төгрөг, нийт **18,445.0** мянган төгрөгийг суутган гүйцэтгэсэн нь байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дагаврыг үүсгэж байна.
- ✓ Сарын ажлын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн үнэлгээг хурлын тэмдэглэлээр албажуулаагүй байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансны ангилал буруу бүртгэсэн 7 нэр төрлийн 13.612.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.
- ✓ Тавилга эд хогшлын дансанд "хөшиг", "шатар", "даам" зэрэг бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн байна.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2022 онд худалдан авсан 139,700.0 мянган төгрөгийн уурын зуухны /500квт/-ын хүчин чадалтай насосыг одоог хүртэл ашиглаагүй боловч **31,458.3** мянган төгрөгийн элэгдлийн зардлыг байгуулж хөрөнгийн үнэ цэнийг бууруулсан байна.
- ✓ Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрэн хөтлөөгүй, ажил гүйлгээгээр бүртгэл тайланд тусгасан байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүнгийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 1-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын мөрөөр дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- ✓ “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх удирдлагын засаглалын менежментийг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулахад бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны дээд хязгаар, хариуцлагын тогтолцоог тус үйлдвэрийн газрын дүрэмд өөрчлөлт оруулах замаар шинэчлэн тогтоож аймгийн ИТХ-ын хяналтад шилжүүлэх нь зүйтэй байна.

- ✓ Дулааны станцын үндсэн ба туслах тоноглолыг шинэчлэн сайжруулахгүй бол үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний өртөг, алдагдлын хэмжээ нэмэгдэж, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахад хүндрэл учирч байгаа тул жил бүрийн төсөвт улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх саналыг үе шаттайгаар ИТХ-аар хэлэлцүүлж үүссэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч байх саналыг тус тус хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сэлэнгэ Энержи” ОНӨААТҮГ-ын дарга Б.Алтансүх танд зөвлөж байна.

- ✓ Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажлын байрны чиг үүрэгт шинжилгээг хийж түүний үр дүнгээр байгууллагын дүрэмд бүтэц зохион байгуулалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, тайлагнал, мэдээллийн ил тод байдал, оролцогч талуудын эрх ашиг, байгууллагын соёл, албан тушаалын жагсаалт, орон тооны норматив, чиг үүргийг тодорхой болгох замаар дүрмийн шинэчлэлийн төслийг боловсруулж аймгийн Засаг даргад танилцуулж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх арга хэмжээг авах.
- ✓ Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа төрөөс баримталж буй Алсын хараа 2050 урт хугацааны болон бүсийн хөгжлийн дунд хугацааны бодлоготой уялдуулан зорилт, арга хэмжээний хүрэх үр дүн, үнэлэх шалгуур үзүүлэлтийн хамт 3-аас дээшгүй жилээр боловсруулж баталгаажуулах.
- ✓ Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбогдуулан эрсдэлийг /хүний нөөцийн, үйлдвэрлэлийн, үйл ажиллагааны, стратегийн, санхүүгийн, нийгэм, засаглалын, мэдээлэл технологийн, зах зээлийн, байгаль орчин, бусад гэх мэт/ ангилан цех газар хэлтэс бүрээр бүртгэх.
- ✓ Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах.
- ✓ Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, үр дүнг тайлагнах.
- ✓ Хүний нөөцийн удирдлага зохин байгуулалтыг сайжруулж үйлдвэрийн газрын ажлын байрны жагсаалтыг гаргах, ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хийх, албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн батлах, ажилд орсон иргэнтэй хөдөлмөрийн гэрээг томилогдсон өдрөөс байгуулан баталгаажуулж байх.
- ✓ Албан хаагчид хамт олноос үзүүлэх хандив тусламж цалингаас суутган тооцохгүй байх.
- ✓ Албан хаагчдын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохдоо журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, үнэлгээг тухайн албан хаагчид танилцуулан хурлын тэмдэглэлээр баталгаажуулж байх.
- ✓ Үндсэн хөрөнгө, бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн 7 нэр төрлийн 13.612.2 мянган төгрөгийн хөрөнгийг залруулах зөвшөөрлийн аймгийн ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх.
- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2022 онд худалдан авсан 139,700.0 мянган төгрөгийн уурын зуухны /500квт/-ын хүчин чадалтай насосыг одоог хүртэл ашиглаагүй боловч **31,458.3** мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулж хөрөнгийн үнэ цэнийг бууруулсан алдааг залруулах.

- ✓ Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу бүрэн хөтлөөгүй, ажил гүйлгээгээр бүртгэл тайланд тусгахгүй байх.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР

Г.ДОРЖДЭРЭМ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА, СХШУАБ

Т.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
"СЭЛЭНГЭ ЭНЕРГО" ОНЛААГУУЙН
ДАРГА
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.АЛТАНСҮХ

Б.УЛАМ-ОРГИЛ

